

Зүүн бүсийн физикийн олимпиад боллоо.

Суралцагчдын физик сэтгэлгээг хөгжүүлэх, физикийн шинжлэх ухаанд шимтэн суралцах хүсэл сонирхлыг дэмжих, багш сурагчдын мэдлэг чадварыг сорих, харилцан туршлага солилцох зорилгын дор ахмад багш **Ч.Цэрэндолгорын** нэрэмжит Зүүн бүсийн Физикийн 23 дугаар олимпиадыг **2022 оны 10 дугаар сарын 15-д Баян-уул сумын Ерөнхий боловсролын сургууль** дээр зохион байгууллаа. Олимпиадад Сүхбаатар аймгаас 2 баг 16 багш суралцагч, Хэнтий аймгаас 1 баг 7 багш суралцагч Дорнод аймгаас Хэрлэн сумын 2,5,8 дугаар сургууль, Хан-Уул цогцолбор сургууль, Шинэ хөгжил цогцолбор сургууль, Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль, Халх гол сумын Ерөнхий боловсролын сургууль, Цагаан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль, Дорнод ахлах сургууль, Долоодой ахлах сургуулийн нийт 10 багийн 62 суралцагч, 13 багш оролцсон Улсын олимпиадын дараа эрэмбэлэгдэх чансаа өндөртэй тэмцээн болж дууслаа.Олимпиадад Улсын физикийн олимпиадын хорооны дарга М.Ганбат, гишүүн Б.Бат-Отгон, н.Төгөлдөр нар бодлого тавьж, комиссоор ажилласан.Тус 23 дугаар олимпиадыг **Б.Батхуяг захиралтай Ерөнхий боловсролын сургуулийн хамт олон** маш өндөр зохион байгуулалт, төлөвлөлтийн дор явуулсан нь олимпиадын үйл ажиллагаа бүрээс харагдаж байсан. Мөн тус олимпиадын үеэр олимпиадад оролцогчид **“Тэр бум мод”** хөтөлбөрт нэгдэж Баян-Уул сумын Ерөнхий боловсролын сургуульд олимпиадын нэрэмжит төглийг байгуулсан байгаа. Зүүн бүсийн 24 дүгээр олимпиадыг 2023 онд хэнтий аймгийн Дадал суманд зохионг байгуулахаар болж олимпиадын тугийг гардуулан өгсөн байгаа.

Олимпиадын амжилтаас дурдвал:

7-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
8-р сургууль	Б.Од	1
5-р сургууль	Т.Цэлмүүн	2
Сүхбаатар аймгийн 1-р баг	С.Тэмүүлэнжав	2
Баян-Уул сумын ЕБС	Б.Саруулбуян	3
Хан-Уул ЦС	Ц.Ариунбат	3
Сүхбаатар аймгийн 2-р баг	Д.Мөнхбуян	3

8-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
8-р сургууль	Г.Сүлд	1
5-р сургууль	Э.Мөнхсоёл	2
Сүхбаатар аймгийн 2-р баг	Н.Мөрөн	2
2-р сургууль	Б.Улсболд	3
Сүхбаатар аймгийн 2-р баг	Д.Сансар	3
Баян-Дун сумын ЕБС	М.Золбаяр	3

9-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
8-р сургууль	Э.Буянзаяа	1
Долоодой сургууль	Т.Содбилэг	2
5-р сургууль	М.Төгөлдөр	2
Баян-Уул сумын ЕБС	Э.Ундрал	3
Шинэ-Хөгжил ЦС	З.Энэрэл	3
Сүхбаатар аймаг, 1-р баг	Э.Номинзул	3

10-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
Долоодой сургууль	Э.Төрбилэг	1
Сүхбаатар аймаг 2-р баг	Г.Алтан-Очир	2

8-р сургууль	М.Мөнхжавхлан	2
Долоодой сургууль	Б.Мөнх-итгэл	3
5-р сургууль	У.Номинжин	3
Хан-Уул Цогцолбор сургууль	Г.Эрдэнэцэцэг	3

11-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
Хан-Уул цогцолбор сургууль	Б.Номинжин	1
Долоодой сургууль	Б.Золбаяр	2
5-р сургууль	Б.Цолмон	2
2-р сургууль	У.Ганзориг	3
Сүхбаатар аймаг, 1-р баг	Ц.Дөлгөөн	3
Хан-Уул цогцолбор сургууль	Б.Батбаатар	3

12-р анги:

Сургууль	Овог нэр	Байр
Сүхбаатар аймаг, 1-р баг	Х.Даваацэрэн	1
Хан-Уул цогцолбор сургууль	Т.Баяржавхлан	2
Долоодой сургууль	Л.Анужин	2
5-р сургууль	Б.Оргил	3
Дорнод ахлах сургууль	Т.Мөнхцэцэг	3
Долоодой сургууль	Г.Билгүүн	3

Багш:

Сургууль	Овог нэр	Байр
Сүхбаатар аймаг, 1-р баг	М.Мэргэнсор	1
Долоодой сургууль	Б.Нямжав	2
Баяндун сумын ЕБС	Ц.Батболд	2
8-р сургууль	Д.Чимэддолгор	3
Сүхбаатар аймаг, 2-р баг	Г.Дэнсмаа	3
Дорнод ахлах сургууль	Б.мөнхтуяа	3

Баг:

1-р байр: Хэрлэн сумын 8-р сургууль

2-р байр: Сүхбаатар аймаг

3-рбайр: Хэрлэн сумын Долоодой сургууль тус тус эзэлсэн.

Мэдээлэл бэлтгэсэн. Мэргэжилтэн Ц.Балжинням